МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

ШИНЭ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ОЮУТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Мэдээ 8

СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА

ЧӨЛӨӨТ СОНГОЛТТОЙ НОМЫН САН

МУИС-ийн номын сан хэрхэн өөрчлөгдөн шинэчлэгдэж байна вэ?

МУИС-ийн номын сан бол 400 гаруй мянган номын фондтой, 25 гаруй мянган байнгын үйчлүүлэгч бүхий Монгол улсын томоохон номын сангийн нэг юм.

Номын сангийн үйлчилгээг дэлхийн тэргүүлэх их дээд сургуулиудын жишигт хүргэх үүднээс дараах өөрчлөлтийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Номын сангийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс Номын сангийн журмыг МУИС-д анх удаа шинээр боловсруулан баталлаа.
- Номын сангийн хөгжлийн бодлогыг боловсруулж, Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбаруудад сургалт, эрдэм шинжилгээ явуулахад шаардлагатай материалаар уншигчдын эрэлт хэрэгцээг бүрэн хангах чанартай фондтой, уншигчдын бие даан суралцах, сонголт хийх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх таатай орчинг бий болгоход чиглэсэн шинэлэг үйлчилгээ, сүүлийн үеийн техник технологи бүхий мэдээллийн төв болгон хөгжүүлэх зорилт дэвшүүллээ.
- Номын сангийн бүтэц зохион байгуулалтыг шинэчилж, бие даасан нэгж болгон өөрчилж, чөлөөт сонголт, төрөлжсөн үйлчилгээ үзүүлдэг, номын фондоо мэргэжсэн багш профессор, оюутан суралцагчдын оролцоотойгоор бүрдүүлдэг, мэдээллийн технологийн хөгжилд суурилсан цахим номын сан болгон хөгжүүлэхээр ажиллаж байна.

МУИС-ийн номын сангийн үйлчилгээнд чөлөөт сонголтын хэлбэр нэвтэрснээр ямар эерэг өөрчлөлт гарах вэ?

- Багш профессор, оюутан суралцагч хэрэгцээ шаардлагад нийцсэн ном зохиолоо өөрөө сонгон авч үйлчлүүлэх
- Авч ашиглах номын тоо хязгаарлагдахгүй болж, үйлчилгээ авахад зарцуулах цаг хэмнэгдэнэ
- Номын санчийн ном олгох буцаан авах зэрэгт зарцуулах цаг хэмнэгдэж, хэрэглэгчид зөвлөгөө үзүүлэхэд зориулах цаг нэмэгдэнэ
- Номтой харьцах, ном ашиглах уншигчийн хэрэглээний соёл сайжирна.

ОЮУТНЫ НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Оюутны нэг цэгийн үйлчилгээ гэж юуг хэлэх вэ?

- МУИС-ийн оюутан суралцагч суралцаж буй байдал, дүнгийн тодорхойлолт зэрэг баримт бичиг авах зэрэг үйлчилгээг Сургалтын албаны ажилтнаас бус Түргэн үйлчилгээний цэгийн машинаас (ТҮЦ) авах үйл явцыг хэлнэ.

ТҮЦ нэвтэрснээр оюутны үйлчилгээ хэрхэн сайжрах вэ?

- Судалгаанаас үзэхэд сургалтын албанаас бүх төрлийн тодорхойлолт авах оюутан суралцагчдын тоо нийт үйлчлүүлэгчдийн дотор эхний 5 байранд багтдаг. Энэ утгаараа энэ үйлчилгээг оюутан өөрөө ТҮЦ машинаас хэвлэн авснаар цаг хугацаа хэмнэгдэж үйлчилгээ түргэн шуурхай болно.
- Сургалтын албаны ачаалал буурч хэмнэгдсэн цаг хугацааг оюутанд зөвлөгөөө өгөх үйлчилгээнд зарцуулах боломж нэмэгдэнэ.

Тус үйлчилгээг хэрхэн авах вэ?

- Оюутны тодорхойлолт, Дүнгийн тодорхойлолт нь МУИС-ийн лого, холбогдох мэдээлэл бүхий А4 -ийн хэмжээтэй цаасан дээр хэвлэгдэх бөгөөд Сургалтын нэгдсэн албаны даргын гарын үсэг, албаны тэмдэгтэй байна.*(Үнэт цаасан дээр хэвлэх асуудлыг холбогдох газруудтай ярьж байгаа бөгөөд ойрын үед нааштай шийдвэрлэгдэнэ гэсэн хүлээлттэй байна)*
- Оюутан суралцагч тодорхойлолт лавлагаа зэрэг үйлчилгээ авахдаа оюутны үнэмлэх, СиСи мэдээллийн системд нэвтрэх нууц үгээ ашиглан ТҮЦ машинаар үйлчлүүлнэ.
- Оюутны болон дүнгийн тодорхойлолт нь Монгол, Англи хэлээр байх бөгөөд оюутан сонгох боломжтой байна. Тодорхойлолт нь хичээлийн жилийн олгосон тухайн улиралдаа хүчинтэй.
- Суралцагч нь тухайн хичээлийн жилд оюутны болон дүнгийн тодорхойлолтыг тус бүрээс 2 удаа үнэ төлбөргүй авах ба үүнээс дээш тоогоор авах тохиолдолд тухай бүр 500 төгрөгийн хураамж төлнө.
- Хураамжийг суралцагч өөрийн СиСи дансыг ашиглан бэлэн бусаар болон машинд 500 -ийн мөнгөн дэвсгэрт хийж бэлнээр төлж болно.

Чөлөөт сонголттой номын сан,

оюутны нэг цэгийн үйлчилгээний машины хаяг

Чөлөөт сонголттой номын сангийн байршил: Хичээлийн II-р байр, Байгалийн ухааны чөлөөт сонголтын уншлагын танхим, Гадаад номын уншлагын танхим

Оюутны нэг цэгийн үйлчилгээний машины байршил: Хичээлийн I, II, III, V, VIII-р байруудад.



СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОИЙН АЛБА

НОМЫН САН